



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, нийт 29,300,000.00 (хорин есөн сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132001645
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
324 дугаар тогтоолын хавсралт



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота ландкрузер-80, 11-08 БУА (арал-hdj810046366)	1994/2009	425152	29,300,000.00	8,000,000.00
	Нийт дүн				8,000,000.00 (найман сая)